



СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.23. №80 (80)

ДЭД САЙД Б.БАЯРМАГНАЙ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 336 ДУГААР АНГИД АЖИЛЛАВ

Улсын Онцгой комиссын шийдвэрээр Дорноговь, Өмнөговь аймагт ажиллаж байгаа Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсэг өчигдөр Зэвсэгт хүчний 336 дугаар ангид ажиллалаа. Ажлын хэсгийн гишүүд ангийн өдөр тутмын үйл ажиллагаа, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид болон офицер, ахлагчдын ажиллаж, амьдарч буй орчин нөхцөлтэй танилцав. Түүнчлэн алба хаагчдын нийгмийн хамгааллын хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа ажил, төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг бэхжүүлэх, тэдний сургалт бэлтгэл, ар тал, ахуй хангалтын өнөөгийн байдалтай нь танилцаж, санал хүсэлтийг нь сонсчээ. Ангийн захирагч хурандаа А.Болдбаатар, “Бид бүхэн өнгөрсөн жил ажиллаж, амьдрах орчин нөхцөлөө сайжруулах чиглэлээр нэлээдгүй ажил төлөвлөн, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал

өнгөрсөн жил штабын бэлтгэл, сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор тактикийн шуурхай удирдлагын төвийг тохижуулж, “Дайчин алдарын танхим”-ыг шинээр байгуулсан. Цэргийн гал тогоонд их засварын ажлыг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн засварын бүлэг, ангиас 40 хүний бүрэлдэхүүнтэй хамтран хийж гүйцэтгэлээ. Цэргийн гал тогоонд агааржуулалт, уур сорогчийг шинээр суурилуулж эрүүл ахуйн чанар стандартад нийцсэн гал тогоотой болсон. Мөн эмнэлгийн байрандаа урсгал засвар хийн, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Цаашид бид Зэвсэгт хүчний 100 жил, тус ангийн 90 жилийн ойг тохиолдуулан тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудыг үе шаттайгаар хийхээр төлөвлөн ажиллаж байна” хэмээн хэлсэн юм.

Зэвсэгт хүчний 336 дугаар анги
Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ



ЦАГ АГААР		
УЛААНБААТАР		
ӨДӨР	ШӨНӨ	
23	9	
ӨМНӨД СУДАН		
ӨДӨР	ШӨНӨ	
33	24	
АФГАНИСТАН		
ӨДӨР	ШӨНӨ	
32	16	
ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.442.00	3.484.00
CNY	442.50	446.60
RUB	38.90	40.60
JPY	25.61	26.10
KRW	2.46	2.60

Ж.Болдбаатар: ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ- ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ГҮҮР БАЙХ ЁСТОЙ

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг өчигдөр ҮБХИС-д ажиллалаа. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, сэтгэл зүйн судалгаа, дүн шинжилгээ хийх арга хэмжээг зохион байгуулах тухай Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/81, Архидан согтуурахтай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай 2021 оны А/83 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагуудад цэргийн алба, сахилга зохион байгуулалтыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, архидан согтуурахтай тэмцэх талаар зөвлөмж, сэрэмжлүүлэг, албан даалгаврыг байнга хүргүүлж, хэрэгжүүлэх үүднээс тогтмол ажлууд хийгдэж байгаа бөгөөд үүнийг Батлан хамгаалах яамнаас шаардан ажиллаж байгаа юм. Энэ хүрээнд тус ажлын хэсэг өчигдөр ҮБХИС-ийн 2021 оны эхний хагас жилд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг урам сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн хийсэн ажилтай танилцсан юм. Үүний дараа хурандаа Ж.Болдбаатар гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлан хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, таслах зогсоох чиглэлээр Батлан хамгаалахын сайдаас тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар мэдээлэл өглөө. Тухайлбал, “Батлан хамгаалах-Иргэний хяналт 1800-1144” тусгай дугаар ажиллах журмыг Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/29



дүгээр тушаалаар баталж, энэхүү тусгай дугаараар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, салбартай холбоотой аливаа мэдээллийг 24 цагийн турш хүлээн авч байна. Мөн Зэвсэгт хүчний ангиудын хяналтын камер болон дагалдах хэрэгслийн судалгаа, тооцоог үндэслэж, Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/80 дугаар тушаалын дагуу эхний ээлжид хугацаат цэргийн алба хаагчидтай нэгтгэл, ангиудын камержуулалтын ажлыг 2021 оны II улиралд багтаан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байгаа талаар болон Батлан хамгаалахын сайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийн ажиллах журмыг Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар баталгаажуулж,

Иргэний зөвлөлийн гишүүдийг томилоод байгаа зэрэг мэдээллүүдийг энэ үеэр өглөө. Үүний дараа тэрээр ҮБХИС-ийн танхимын дарга нараас дээших албан тушаалтуудад чиглэсэн үүргийг өглөө. Үүнд, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр үр дүнтэй ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх; 1. Сонсогч оюутнуудтай хийх сургалт сурталчилгааны ажлыг тэдний онцлогт тохирсон, үр дүнтэй шинэлэг аргаар явуулах, төрийн бус байгууллагуудын оролцоо дэмжлэгийг хослуулан хэрэгжүүлэх; 2. Сургуулийг архигүй, архидалтгүй орчин болгох бүх талын үр дүнтэй аргыг хэрэгжүүлж ажиллах; 3. Сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх, ёс суртахуун, бие бялдрын өндөр чадамжтай, орчин цагийн

шаардлага хангасан шинэ залуу бүрэлдэхүүнийг бэлтгэж, хуулиар хүлээсэн үүргээ мадаггүй биелүүлэх; 4. Удирдах албан тушаалтны ёс зүйн асуудалд үлгэрлэх, манлайлах, хариуцлагатай байж хүлээн зөвшөөрөгдөх, мэдлэг чадвартай, бодлогыг хамт олноороо шийдвэрлэдэг байхад анхаарч ажиллах зэрэг үүргийг өглөө. Үргэлжлүүлээд тэрээр Үндэсний батлан хамгаалахын их сургууль-Хөгжил дэвшлийн гүүр байх ёстойг чухалчлаад Батлан хамгаалахын сайдаас “Хандлагаа өөрчилж-Хариуцлагаа дээшлүүлье” уриалгыг хүн бүхэн дор бүрнээ ажил, албандаа хэрэгжүүлэн ажиллахыг захилаа.

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 13
2021.06.23.
/ЛХАГВА ГАРАГ/

ЭРХТНИЙ ТЭНГЭРТ ОДТОЙ, ХАР БАР ӨДӨР

Үс засуулбал:
Жаргал ирнэ.
Наран ургах, шингэх:
04.53-20.55

Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Хурьцахуй

Суудал:
Мод

Аргын тооллын 6 сарын 23, Буд гараг. Өдрийн наран 4 цаг 53 минутад мандан, 20 цаг 55 минутад жаргана. Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамагй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, сүм дуганыг сэргээх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золге гаргах, бомбын үйл, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
95.816	63.945	447/11
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ		
НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
3166(53)	365	2746

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 179,245,386

Эдгэрсэн
Нийт: 163,798,559

Нас барсан
Нийт: 3,881,890



ХУРАНДАА ЦОЛ ОЛГОЛОО

Орчин цагийн Онцгой байдлын байгууллага нэгдсэн тогтолцоонд шилжсэний 17 жилийн ойн баярыг тохиолдуулан ЗХЖШ-ын даргын тушаалаар Нийслэлийн Онцгой байдлын газрын дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Эрдэнэбаатар, тус газрын Нийслэлийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга,

дэд хурандаа Д.Оюунбат, Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа Б.Цогбадрах, Хан-Уул дүүргийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Д.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах ангийн захирагч, дэд хурандаа Ш.Мэндсайхан нарт албан тушаалын зэрэглэлийн хурандаа цол олголоо. ЗХЖШ-ын

дарга, дэслэгч генерал Д.Ганзориг шинээн хурандаа нарт "Эрхэм сайхан цолныхоо эзэн нь болж гялалзаарай. Эх орон, ард түмэндээ өргөсөн тангарагтаа үнэнчээр хүчин зүтгэж, гал усны гашуун зовлон, гамшгийн аюулыг цаг ямагт сөрөн тэмцэж байдаг та бүхэн болон хамт олонд нь өндөр амжилт хүсье" гэлээ. Чиглэлээр санал солилцсон юм.

ЦАХИМ ШУУДАНД

ЖУРМЫН НӨХРӨӨ ХҮНДЭТГЭЛТЭЙГЭЭР УГТАН АВЧ, ҮДЭН ГАРГАВ

Зэвсэгт хүчний 339 дүгээр анги



Ховд аймгаас Улаанбаатар хот руу 1500 км-ын холын зайн гүйлт хийж байгаа Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э.Даваажамц энэ оны 6 дугаар сарын 21-ний өдөр гэхэд 830 км замыг туулж Баянхонгор аймгийн төвд ирсэн юм.

Ахлах ахлагч Э.Даваажамцыг ирэхэд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн удирдлага, ахлагчийн зөвлөл, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб болон хэвлэл мэдээллийн байгууллагууд Баянхонгор аймгийн самбартай хөтөл дээр алд цэнхэр

хадаг, мөнгөн аягатай сүүтэй хүндэтгэлтэйгээр угтан авлаа. Мөн түүнд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хамт олон Баянхонгор аймгийн төвөөр дайран өнгөрөхөд замын хоёр талаар зогсож амжилт хүсэн хүндэтгэл үзүүлсэнд тэрээр баярлаж талархсанаа илэрхийлсэн юм.

Ахлах ахлагч Э.Даваажамц Баянхонгор аймгийн Түйн голын эрэг дээр хоноглож, энэ сарын 22-ны өглөөний 6 цагт Өлзийт сумын чиглэлд гүйлтээ үргэлжлүүлсэн ба түүнийг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн удирдлага

болон Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын хамт олон үдэн гаргалаа.

Энэ үеэр түүнийг Баянхонгор аймаг дахь Юнителийн салбарын хамт олон замд нь угтан авч ухаалаг гар утас болон дататай дугаар бэлэглэж, тэсвэр хатуужлыг нь дэмжиж байгаагаа илэрхийлэв. Ингэснээр тэрээр Монгол орноо хөндлөн гулд туулахдаа Юнителийн 4G сүлжээг ашиглан анги нэгтгэл, гэртээ үлдсэн энхрий үртэйгээ онлайнар холбогдох боломж олгож байгаа юм.

Ахмад С.АМАРЖАРГАЛ

ДЭЛХИЙД

“ФОРД” НИСЭХ ОНГОЦ ТЭЭВЭРЛЭГЧ ХӨЛӨГ ОНГОЦ, ДЭЛБЭРЭЛТИЙН ЦОХИХ ДОЛГИОНД ӨРТӨХ ҮЕИЙН ТУРШИЛТ ХИЙЛЭЭ

Доктор (Ph.D), хурандаа Р.ЭНХБОЛД

АНУ-ын тэнгисийн цэрэг, “Жералд Форд” нисэх онгоц тээвэрлэгч хөлөг онгоцны хажууд 18,1 тонн тэсрэх бөмбөг дэлбэлж, уг хөлөг онгоцыг дэлбэрэлтийн цохих долгионд өртөх үеийн туршилтыг амжилттай хийлээ.

АНУ-ын газар зүйн нийгэмлэгээс уг тэсрэлтийг 3,9 баллын газар хөдлөлттэй дүйцэхүйц чичиргээ үүсгэсэн гэж тооцоолжээ. Бараг 20 тэрбум ам.доллар /57 их наяд төгрөг/-ын өртөгтэй уг нисэх онгоц тээвэрлэгч “Жералд Форд” хөлгийг Америкийн тэнгисийн цэрэг 2017 онд зэвсэглэлд авсан боловч хөлгийн туршилт, судалгааны ажил 2023 он хүртэл үргэлжилнэ. Нисэх онгоц тээвэрлэгч нь 100 мянган тонн усан түрцтэй, 333 метр урт, 76 метр өндөртэй, “А1В” загварын 2 нэгж цөмийн хөдөлгүүртэй, 56 км/цаг хурдтай усанд хөвөх ба уг хөлөгт 4539 усан цэрэг ажиллаж, 75 нэгж нисэх онгоц тээвэрлэх боломжтой юм.

Эх сурвалж: navy.mil



ЦАГ ҮЕ

12-ООС ДЭЭШ НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙГ ИРЭХ ДОЛОО ХОНОГООС ВАКЦИНЖУУЛНА



Эрүүл мэндийн сайд С.Энхболд жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, хүүхдүүдийн вакцинжуулалтын талаар мэдээллийг АБГБ-ын байнгын хорооны хуралдааны үеэр өглөө. Эрүүл мэндийн сайд С.Энхболд, “Жирэмсэн эхчүүдийн вакцинжуулалт зургадугаар сарын 10-наас эхэлсэн. Үүнд 14-37 долоо хоногтой жирэмсэн ээжүүдэд

“Файзер” вакциныг хийж байна. Монгол Улс 2.5 сая вакцин худалдан авах гэрээ хийгээд эхний ээлжийн тунгаа авсан. Вакцины цэгүүдэд ачаалал үүсгэхгүйн тулд цаг авч үйлчлүүлнэ. 16-17 насны хүүхдүүдийг вакцинжуулаад эхэлсэн. ДЭМБ-ын вакцин хариуцсан зөвлөлтэй цахимаар холбогдож зөвшөөрлийг авсан. Тиймээс 12-15 насны

хүүхдүүдийн вакцинжуулалтыг энэ долоо хоногийн төгсгөл, ирэх долоо хоногоос эхлэх төлөвлөгөө гаргаж бэлэн байдлаа хангаж байна” гэв.

Түүнчлэн хөхүүл ээжүүдэд тавдугаар сараас вакцин хийж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 860 хөхүүл ээж, 16-17 насны 10,294 хүүхэд “Файзер” вакцинд хамрагдаад байгаа ажээ.

ИХ ДЭЭД СУРГУУЛЬД ОРОН НУТГААС ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ



Монголын их, дээд сургуулиудын консорциумын гишүүн их, дээд сургууль,

колледжид орон нутгаас 2021-2022 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журмыг

танилцуулж байна.

Элсэлтийн төв комисс аймаг, орон нутаг, нийслэлээс дээрх сургуулиудад зургаадугаар сарын 26-наас долоодугаар сарын 10-ны өдрүүдэд оюутан элсүүлнэ. Боловсролын үнэлгээний төвөөс баталгаажуулсан ЭЭШ-ын оноо нь оюутан элсүүлэх албан ёсны үндсэн баримт байх юм.

Оюутан элсүүлэх босго оноо:

- Төрийн өмчийн сургууль-480
- Төрийн бус өмчийн сургууль-410
- Орон нутгийн их, дээд сургууль, коллеж-400 байх бөгөөд суурь, дагалдан хичээлүүдээс тус бүр нэг хичээлийн оноог босго оноонд тооцно.

БОРОО ИХТЭЙ ҮЕД ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХОД ЮУГ АНХААРАХ ВЭ?

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба



Зургаадугаар сарын дунд үеэс 7 дугаар сарын эхний өдрүүдэд баруун аймгуудын болон нутгийн зарим газар, төв болон зүүн аймгуудын ихэнх нутаг, говийн аймгуудын зарим хойд хэсгээр дуу цахилгаантай аадар бороо орох тул гол мөрөн, нуур цөөрмийн төвшин нэмэгдэх үеэр усны аюулын эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг Ус, цаг уур орчны шинжилгээний газраас анхаарууллаа.

Зургаадугаар сарын оролцож байгаа жолооч та цаг агаарын талаарх мэдээ мэдээллийг цаг алдалгүй сонсож, мэргэжлийн байгууллагаас өгч буй сэрэмжлүүлэг, анхааруулгыг дагах, байгалийн таагүй үзэгдлээс шалтгаалан замын үзэгдэх орчин хязгаарлагдах, зорчих хэсэгт гулгаа үүсэх эрсдэлтэй тул замын хөдөлгөөнд оролцохдоо урьдчилан сэргийлэхийг Ус, цаг уур орчны шинжилгээний газраас анхаарууллаа.

хараа хяналтгүй орших, гол эргийн дагуу тоглуулахгүй байхыг анхааруулж байна. Түүнчлэн тээврийн хэрэгслээр гол гатлахдаа гарамтай газраар гарч, замын гадаргуу, тээж яваа ачаа, тээврийн хэрэгслийн онцлог хурдаа тохируулан явж, аюулгүй байдлаа хангаж жолооч, зорчигч нар хамгаалах бүсийг хэрэглэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоож зайлшгүй зогсолт хийхдээ аюулгүй байдлыг хангаж зорчих хэрэгтэй. Харанхуй үед хөдөлгөөнд оролцохдоо өөдөөс ирж яваа тээврийн хэрэгсэлд гэрэл шилжүүлж аюулгүй байдлыг хангах бөгөөд техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, замын хөдөлгөөнд оролцохыг Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас анхаарууллаа.

Ахмад М.МӨНХБАЯР